

“АГААРЫН ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ”-НИЙ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Нэг. Үндсэн үйлчилгээ:

- 1.1. Агаарын тээврийн үйлчилгээ үзүүлэгч нь “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн салбарын ээлжийн ажилтнуудыг даваа гариг бүр Улаанбаатар → Өмнөговь аймгийн Цогтцэций сум→ Улаанбаатар чиглэлд агаараар зорчуулах үйлчилгээ үзүүлнэ.
- 1.2. Захиалагч нь зорчигчдийг нисэх буудал хүргэх ажлыг зохион байгуулна.

Хоёр.Тээврийн үйлчилгээ үзүүлэгчид тавигдах шаардлага:

2.1. Ерөнхий шаардлага

- 2.1.1. Монгол улсад агаарын тээврийн үйл ажиллагаа явуулах эрх бүхий улсын бүртгэлийн гэрчилгээтэй байх.
- 2.1.2. Захиалгат нислэгийн чиглэл, давтамжийг тодорхойлсон цагийн хуваарийг ирүүлэх.
- 2.1.3. Агаарын хөлгийн техникийн үзүүлэлтүүдийг харуулсан дэлгэрэнгүй танилцуулгыг ирүүлэх.
- 2.1.4. Захиалгат нислэг үйлдэх чиглэлд гаргасан техник эдийн засгийн үндэслэл, нислэгийн зардлыг үнэн бодитой тооцоолсон байх.
- 2.1.5. Нислэг үйлдэх агаарын хөлөг захиалгат чиглэлд нислэг үйлдэх цагийн хуваарийн зохицуулалтыг хийсэн танилцуулга.
- 2.1.6. Агаарын хөлөг нь Тавантолгойн нисэх буудлын шороон зурваст газардах, хөөрөх чадвартай байх. Шороон зурваст газардах, хөөрөх чадвартайгаа нотлох техникийн үзүүлэлт, баримтыг ирүүлэх.
- 2.1.7. 7 хоног тутмын даваа гаригт нэг талдаа 2 хүртэлхи нислэгээр 135-145 хүн тээвэрлэх хүчин чадалтай байх.
- 2.1.8. Тавантолгойн нисэх буудлын шороон зурваст агаарын хөлөг газардах, хөөрөх үйлдэлд эрсдэлийн үнэлгээ хийж, болзошгүй эрсдлүүдийг арилгаж ажиллах чадвартай байх.
- 2.1.9. “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн ажилчдад нислэгийн үеийн аюулгүй ажиллагаа, ачаа тээвэрлэлтийн талаарх сургалт зохион байгуулах.

2.2. Тусгай шаардлага. /Агаарын тээврийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлүүд/

- 2.2.1. Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ болон гэрчилгээний хавсралт үйл ажиллагааны тодорхойлолтын хугацаа хүчинтэй байх.
- 2.2.2. Техник үйлчилгээний байгууллагын гэрчилгээ болон гэрчилгээний хавсралт үйл ажиллагааны тодорхойлолтын хугацаа хүчинтэй байх
- 2.2.3. Агаарын хөлгийн улсын бүртгэлийн хүчинтэй гэрчилгээтэй байх.
- 2.2.4. Нислэгт тэнцэх чадварын гэрчилгээний хугацаа хүчинтэй байх.
- 2.2.5. Агаарын хөлгийн дуу чимээний гэрчилгээтэй байх.
- 2.2.6. Агаарын хөлгийн радио станцын зөвшөөрлийн гэрчилгээтэй байх
- 2.2.7. Агаарын тээвэрлэгчийн зорчигчийн, зорчигчийн амь нас, эрүүл мэнд, ачаа, тээш агаарын хөлгийн багийн гишүүдийн даатгал, гуравдагч этгээдийн өмнө хүлээх хариуцлагын даатгалын гэрээний хугацаа хүчинтэй байх.
- 2.2.8. Тоног төхөөрөмжийн ашиглалтад тэнцэх гэрчилгээний хугацаа хүчинтэй байх.

2.2.9. Нислэгийн үйл ажиллагаанд оролцож байгаа нисгэгч, инженер, агаарын хөлгийн диспетчер зэрэг иргэний нисэхийн мэргэжлийн үнэмлэх, зэрэглэл эзэмшигч нар нь ИНД-61, ИНД-63, ИНД-66, ИНД-67 дүрмийн холбогдох заалтуудыг хангасан иргэний нисэхийн мэргэжлийн үнэмлэх, зэрэглэл эзэмшигч байх.

2.2.10. Тавантолгойн нисэх буудлын шороон зурваст газардах, хөөрөхтэй холбоотой хариуцлаг үүсвэл бүрэн хариуцах тухай батлах

Гэрээг хэрэгжүүлэх чадвартайг нотлохын тулд дараах нэмэлт нотлох баримтыг үнийн саналын хамт ирүүлнэ. Үүнд:

1. Улсын бүртгэлийн гэрчилгээ-нотариатаар баталгаажуулах
2. Байгууллагын танилцуулга
3. ШШГЕГ-ын тодорхойлолт /Үнийн санал ирүүлэх өдрөөр хүчинтэй байх/
4. Захиргааны хэргийн шүүхийн тодорхойлолт /Үнийн санал хүлээн авах өдрөөр хүчинтэй байх/
5. Шүүхийн төрөлжсөн архиваас Иргэний хэргийн шүүхийн тодорхойлолт /Үнийн санал хүлээн авах өдрөөр хүчинтэй байх/
6. Татварын цахим тодорхойлолт /Үнийн санал хүлээн авах өдрөөр хүчинтэй байх/
7. 2019 оны санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийн хамт
8. Сүүлийн 3 жил буюу 2018, 2019, 2020 онуудын аль нэг жилд ижил төрлийн бараа буюу сэлбэг нийлүүлсэн тухай гэрээний хуулбар мөн гэрээг дүгнэсэн акт, бүрэн гүйцэтгэсэн болохыг тодорхойлсон өмнөх үйлчлүүлэгчийн тодорхойлолт
9. Улсын бүртгэлийн гэрчилгээг эх хувиас хуулбарлаж ирүүлэх
10. Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ болон гэрчилгээний хавсралт үйл ажиллагааны тодорхойлолтыг эх хувиас хуулбарлаж ирүүлэх /хугацаа хүчинтэй байх/
11. Агаарын хөлгийн улсын бүртгэлийн гэрчилгээг эх хувиас хуулбарлаж ирүүлэх
12. Нислэгт тэнцэх чадварын гэрчилгээг эх хувиас хуулбарлаж ирүүлэх
13. Агаарын хөлгийн дуу чимээний гэрчилгээг эх хувиас хуулбарлаж ирүүлэх
14. Агаарын хөлгийн радио станцын зөвшөөрлийн гэрчилгээг эх хувиас хуулбарлаж ирүүлэх
15. Техник үйлчилгээний байгууллагын гэрчилгээ болон гэрчилгээний хавсралт үйл ажиллагааны тодорхойлолтын хугацаа хүчинтэй байх
16. Тоног төхөөрөмжийн ашиглалтанд тэнцэх гэрчилгээний хугацаа хүчинтэй байх
17. Захиалгат нислэгийн чиглэл, давтамжийг тодорхойлсон цагийн хуваарийг ирүүлэх
18. Агаарын хөлгийн техник, эдийн засгийн үзүүлэлтүүдийг харуулсан дэлгэрэнгүй танилцуулгыг ирүүлэх
19. Захиалгат нислэг үйлдэх чиглэлд гаргасан техник эдийн засгийн үндэслэл, нислэгийн зардлыг үнэн бодитой тооцоолсон байх /тооцооллыг ирүүлэх/

20. Нислэг үйлдэх агаарын хөлөг захиалгат чиглэлд нислэг үйлдэх цагийн хуваарийн зохицуулалтыг хийсэн танилцуулга
21. Үйлчилгээ үзүүлэх агаарын хөлөг нь Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт байрлах Тавантолгойн нисэх буудлын шороон зурваст газардах, хөөрөх чадамжтай болохыг нотлох албан тоотыг мэргэжлийн байгууллага буюу Иргэний нисэхийн ерөнхий газраас гаргуулан ирүүлэх
22. 7 хоног тутмын даваа гаригт нэг талдаа 2 хүртэлх нислэгээр **135-145** хүн тээвэрлэх хүчин чадалтай байх.
23. Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт байрлах нисэх буудлын шороон зурваст агаарын хөлөг газардах, хөөрөх үйлдэлд эрсдэлийн үнэлгээ хийж, болзошгүй эрсдэлүүдийг арилгаж ажиллах чадвартай байх. /албан тоотоор дурдаж нотлох баримтыг ирүүлэх/
24. “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн ажилтнуудад нислэгийн үеийн аюулгүй ажиллагаа, ачаа тээвэрлэлтийн талаархи сургалт зохион байгуулах
25. Нислэгийн үйл ажиллагаанд оролцож байгаа нисгэгч, инженер, агаарын хөлгийн диспетчер зэрэг иргэний нисэхийн мэргэжлийн үнэмлэх, зэрэглэл эзэмшигч нар нь ИНД-61, ИНД-63, ИНД-66, ИНД-67 дүрмийн холбогдох заалтуудыг хангасан байна. /нотлох баримт бичгийн эх хувийн хуулбарыг нотариатаар баталгаажуулж ирүүлэх/
26. Агаарын тээвэрлэгчийн, зорчигчийн амь нас, эрүүл мэнд, ачаа тээш болон агаарын хөлгийн багийн гишүүдийн даатгал, гуравдагч этгээдийн өмнө хүлээх хариуцлагын даатгалын гэрээний хугацаа хүчинтэй байх /нотлох баримт бичгийн эх хувийн хуулбарыг нотариатаар баталгаажуулж ирүүлэх/
27. Нислэгийн аюулгүй ажиллагаатай холбоотой болон даатгалын гэрчилгээний хугацаа нислэг үйлдэх хугацаанд хүчинтэй байх /нотлох баримт бичгийн эх хувийн хуулбарыг нотариатаар баталгаажуулж ирүүлэх/
28. Дээр дурдсан даатгалын гэрээнүүд нь гэрээ байгуулагдсанаас хойш 1 жилийн хугацаанд хүчинтэй байх шаардлагатай бөгөөд хэрэв уг шаардлагыг хангахгүй тохиолдолд гэрээ хүчин төгөлдөр үргэжлэх хугацаанд гэрээг сунгах болон шинэчлэн байгуулах бүрэн боломжтой тухайг нотолсон албан тоотыг өөрийн болон даатгалын байгууллагаас гаргаж ирүүлэх.
29. Техникийн тодорхойлолтонд заасан тусгай шаардлагуудыг хангасан өөрийн эзэмшлийн агаарын хөлөгтэйг нотлох баримтыг ирүүлэх. Өөрийн эзэмшлийн биш түрээсээр ашигладаг агаарын хөлөгтэй бол уг тендерт шалгарч гэрээ байгуулснаас хойш 1 жилийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчлэх түрээсийн гэрээний хуулбарыг нотариатаар баталгаажуулж эсвэл 1 жилийн дотор түрээсийн гэрээний хугацаа дуусгавар болох бол түрээсийн гэрээг шинэчлэх, эсвэл сунгах замаар гэрээний хугацаанд гэрээний үүргээ бүрэн биелүүлэх боломжтой тухайг баталсан албан тоотыг өөрийн байгууллага болон түрээслэгч талаас гаргаж ирүүлэх.

Тендерт оролцогч нь дараах чиглэлээр тооцож үнэ ирүүлнэ. Үнийг тооцохдоо нэг удаагийн нислэгийн үнэ, нийт үнэ, Тавантолгой нисэх буудлын үйлчилгээний хураамжийг тооцож ирүүлнэ.

- Улаанбаатар хот - Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт байрлах онгоцны буудал - Улаанбаатар хот чиглэлээр тээвэрлэх үнэ (нэг талдаа 2 хүртэлх нислэгээр 135-145 хүн)